

АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

А. ТАНИЛЦУУЛГА

1. Гэрээний дугаар:	2. Байгууллагын нэр: Эрүүл мэндийн яам
3. Төслийн нэр: Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах бэлэн байдлыг хангах төсөл	3.1. Албан тушаал: Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтэн
4. Ажлын байрыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: Төслийн зохицуулагч	

Б.ЧИГ ҮҮРЭГ

1. Ажлын байрны зорилго:	Энэхүү ажлын байрны зорилго нь төсөл хэрэгжүүлэх нэгж, төсөл хэрэгжүүлэгч байгууллагад дэмжлэг үзүүлж дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оршино: 1) төслийн гарааны болон хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтийг үүсгэж, түүний дагуу хэрэгжилтийг хянах, 2) төслийн хүрээнд хэрэгжсэн бүх үйл ажиллагааны үр дүнг цаг хугацаанд нь үнэлэх, 3) гэрээний хэрэгжилт, хяналт.
2. Ажлын байрны гол зорилтууд:	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн хүрээнд гарсан тайланг хянаж, тэдгээрт буй гарц, үр дүнтэй холбоотой мэдээллийг хянан, цуглуулан төслийн улирал, хагас жил, жил, хаалтын тайланд монгол, англи хэл дээр нэгтгэн оруулах, ийнхүү оруулахдаа гүйцэтгэл, бүтээгдэхүүний үр дүнг онцлон дурдах. 2. ЭМЯ-ны холбогдох газартай хамтран ХШҮ-ний тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх. 3. Төслийн бүрэлдэхүүн хэсэг бүрийн хүрээнд хэрэгжиж буй гэрээ, арга хэмжээ нь тавьсан зорилго, үр дүндээ хүрч буй эсэхэд хяналт тавих, улмаар төслийн завсрын шалгуур үзүүлэлт, хөгжлийн зорилтыг хангуулахад оруулах хувь нэмрийг нь нэмэгдүүлэх зөвлөмж гаргах. 4. Төслийн хэрэгжилтийн явцаг тогмтол хянах. 5. Цахим эрүүл мэндийн төслийг хаах, тус төслийн Хаалтын тайланг бичихэд дэмжлэг үзүүлэх. 6. Төслийн гомдол барагдуулах журмын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх. 7. Төсөл хэрэгжүүлэх зааварт ХШҮ-тэй холбогдуулан дурдсан бусад ажлыг гүйцэтгэх, Төслийн зохицуулагчаас даалгасан үндэслэл бүхий бусад ажлыг хийж гүйцэтгэх.
3. Ажлын байрны үндсэн үйл ажиллагаа:	Хэрэгжүүлэх хугацаа
Зорилт 1. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх	

1.1 Төслийн бүх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх	Тухай бүр
1.2 Өдөр, долоо хоног, сар тутам төслийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх замаар төслийн хяналт-шинжилгээг хэрэгжүүлэн, илэрсэн зөрчил, доголдлыг залруулахад тухай бүр дэмжлэг үзүүлэх.	Тухай бүр
1.3 Халдварын дэгдэлт, вакцинжуулалтын хамрах хүрээг мэдээлэх, бууруулах зорилгоор судалгаа хийх, эпидемиологийн тодорхой мэдээлэл цуглуулахад дэмжлэг үзүүлэх (түүний дотор судалгааны асуулга, асуулгын гарын авлага боловсруулах гэх мэт).	Тухай бүр
Зорилт 2. ХШҮ-ний тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх.	
2.1 Судалгаа, шинжилгээний үр дүнг тайлбарлах ажлыг хөнгөвчлөх зорилгоор ажлын даалгавар, асуулга, судалгааны цар хүрээг боловсруулах	Шаардлагатай тохиолдолд
Зорилт 3. Төслийн явцыг баримтжуулсан тайланг тогтмол боловсруулах, тайлагнах	
3.1 Төслийн үйл ажиллагаа нь зорилго, зорилтдоо нийцэж буй эсэхийг баталгаажуулахын тулд төслийн үйл ажиллагааны явцыг хянах, хянахад Төслийн зохицуулагчид дэмжлэг үзүүлэх	Тухай бүр
3.2 Холбогдох оролцогч талуудад зориулсан төслийн тойм, явцын тайланг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.	Тухай бүр
3.3 Төслийн хэрэгжилтийн талаарх бүх мэдээллийг агуулсан мэдээллийн санг бүрдүүлж, хөтлөх	Шаардлагатай тохиолдолд
3.4 Зээлийн хэлэлцээр, Төсөл хэрэгжүүлэх зааварт заасан нөхцөл болзолын хэрэгжилт, нийцлийг хангах	Шаардлагатай тохиолдолд
Тэмдэглэл: Үйл ажиллагааны хэрэгжүүлэх хуваарийг жилийн ажлын төлөвлөгөөгөөр тодорхойлно.	

В. ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Ажлын байранд тавигдах шаардлага	1.1 Ерөнхий шаардлага:	Шалгуур	Заавал тавигдах шаардлага	Зөвлөмж болгож буй
		Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	
		Мэргэжил	Бизнесийн удирдлага, эрүүл мэнд, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй зэрэг чиглэлээр их дээд сургууль төгссөн	
		Туршлага	<ul style="list-style-type: none"> Мэргэжлээрээ дор хаяж 2-оос доошгүй жил ажилласан, Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 1-ээс доошгүй жил ажилласан туршлагатай, 	

			<ul style="list-style-type: none"> • Цахим хяналт-шинжилгээ, үнэлгээний туршлагатай, вебд суурилсан ХШҮ-ний туршлагатай бол давуу тал болно, • АХБ эсвэл ДБ-нд ХШҮ-ний туршлагатай бол давуу тал болно, • Эрүүл мэндийн салбарт хяналт-шинжилгээ, үнэлгээний ажил хийж байсан бол давуу тал болно. 	
		Ур чадвар	<ul style="list-style-type: none"> • Чанарын судалгааны арга зүйг сайн эзэмшсэн, тоон болон чанарын судалгааны хосолсон судалгааны аргазүйг сайтар эзэмшсэн байх, • Төслийн удирдлага, мэдээллийн дүн шинжилгээ хийх чадвартай, • Шударга, хариуцлагатай, багаар ажиллах чадвар сайтай 	<ul style="list-style-type: none"> • STATA, SAS, R, SPSS зэрэг статистикийн програмуудаар дүн шинжилгээ хийх чадвартай байх, • Дүн шинжилгээ хийх ур чадвартай байх, • Чанарыг судалгаанд дүн шинжилгээ хийж чаддаг байх
	1.2 Тусгай шаардлага	Англи хэлний бичгийн болон ярианы ахисан түвшний чадвартай байх (холбогдох баримт бичгээр баталгаажуулах)		